



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 17/10

Номгон

Ламын гэгээн Лувсанданзанжанцаны
түмэн өлзий гийсний түүхт 380 жилийн ойн
хүрээнд зохион байгуулсан ажлын тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус 17 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монголын шашин соёлын нэрт зүтгэлтэн, Их соён гэгээрүүлэгч, Монголын маарамбын оройн чимэг, Хамба номун хан, ханчин чойжил Эрдэнэбандид хутагт, ууган зурхайч, Монголын бурхны шашны 3 зулын нэг Ламын гэгээн Лувсанданзанжанцаны түмэн өлзий гийсний түүхт 380 жилийн ой, түүний наймдугаар дүр Данзанжамбалчойжишинэн гэгээнтэнд бат оршил өргөх хүндэтгэл, даншиг наадмыг амжилттай зохион байгуулсныг сайшаасугай.

2. Аймгийн Засаг дарга Г.Батжаргалд ДААЛГАХ нь:

2.1. Ойн үйл ажиллагааг зохион байгуулахад идэвх, санаачилгатай ажилласан байгууллага, албан тушаалтныг шагнаж урамшуулсугай.

2.2. Түүхэн их ой зохион байгуулах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт, иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор гаргасан “Даншиг наадам-2019” сугалааны борлуулалт, гүйцэтгэл, тохиролыг дэлгэрэнгүй тайлбарлаж иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, ойн хүрээнд орон нутагт орсон хуримтлагдсан хөрөнгийн орлогод авч орон нутгийн өмчид бүртгэлжүүлэх, санхүүжүүлж чадаагүй зарлагын тооцоог нарийвчлан гаргаж орон нутгийн төсөвт тусгаж аймгийн иргэдийн Төлөөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190027